

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Геологийн төв лаборатори ТӨҮГ-ын 2018 оны санхүүгийн
тайлангийн аудит

Аудитын код: САГ-2019/68/СТА-ТӨҮГ

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	2
2	Аудитын тайлан.....	4
	2.1. Оршил.....	4
	2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
	2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
	2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
	2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
	2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
	2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
	2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	7
	2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	7
	2.8.2 . Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудал.....	8
	2.8.2.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээс шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал	8
	2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
	2.10. Үйл ажиллагааны орлого, зардал, гүйцэтгэл, түүний талаарх тайлбар, тодруулга.....	8
	2.11. Шилэн дансны мэдээлэл	9
	2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	9
	2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
3	Менежментийн захидал.....	10
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	12
	4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	12
	4.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан.....	13
	4.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	14
	4.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	15
	4.5 Аудит хийсэн зорилтот түвшин, гүйцэтгэл, түүний талаарх тайлбар, тодруулгын тайлан.....	16
5	Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	17

Товчилсон үгийн жагсаалт

СТОУС	Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

ГЕОЛОГИЙН ТӨВ ЛАБОРАТОРИ
ТӨҮГ-ЫН ЗАХИРАЛ Ө.ОЮУНБААТАР
ТАНАА

2019.03.15 № 06/493
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Геологийн төв лаборатори ТӨҮГ-ын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Геологийн төв лаборатори ТӨҮГ-ын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Геологийн төв лаборатори ТӨҮГ-ын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Геологийн төв лаборатори ТӨҮГ нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Геологийн төв лаборатори ТӨҮГ-ын 2018 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг тус ТӨҮГ-ын захирал Ө.Оюунбаатар Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Геологийн төв лаборатори ТӨҮГ-ын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, тодруулгад аудит хийлээ.

Геологийн төв лаборатори ТӨҮГ-ын 2018 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт гаргах нь энэхүү аудитын зорилт байв.

Геологийн төв лаборатори ТӨҮГ-ын удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг НББОУС, СТОУС болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 02 дугаар сарын 20-ноос 03 дугаар сарын 05-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 03 дугаар сарын 15-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Геологийн төв лаборатори ТӨҮГ-ын удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, Эвиденсе Аудит ХХК хариуцаж хэрэгжүүлэв.

Геологийн төв лаборатори ТӨҮГ нь 2018 оны санхүүгийн тайлан, тодруулгын хамт 2019 оны 02 дугаар сарын 18-ны 191 тоот албан бичгээр Эвиденсе Аудит ХХК-д ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, НББОУС, СТОУС, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Геологийн төв лаборатори ТӨҮГ-ын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Геологийн төв лаборатори ТӨҮГ-ын үйл ажиллагааны үндсэн зорилт нь Монгол Улсын эрдсийн шинжилгээний үнэн зөв, баталгаатай үр дүнгээр захиалагч, үйлчлүүлэгчийг хангахад оршино. Тус газар нь Монгол орны төрөл бүрийн чулуулаг, хүдэр, баяжмал, байгаль орчин, ашигт малтмалын технологийн боловсруулалтын бүтээгдэхүүнээр нийт 100 гаруй төрлийн СЗ, АСЗ зохион бүтээж, дэлхийд нэртэй компаниудаар дамжуулан олон улсын зах зээлд нийлүүлдэг.

Үйл ажиллагааны чиглэл:

- Эрдсийн түүхий эдийн тоон ба хагас тоон шинжилгээ
- Экспортын бүтээгдэхүүнд хийх экспертиз шинжилгээ
- Байгалийн цацраг идэвхит материалын шинжилгээ
- Стандартчилсан загвар, аттестатчилсан стандартчилсан загварын (СЗ/АСЗ) үйлдвэрлэл, борлуулалт
- Нүүрсний элементийн болон техникийн иж бүрэн шинжилгээ
- Байгаль орчны судалгаа, шинжилгээ
- Бодисын найрлагын судалгаа
- Ашигт малтмалын баягжигдах шинж чанарын лаборатори технологийн туршилт
- Хүдрийн бус ашигт малтмалын физик механикийн шинж чанарын судалгаа
- Лабораторийн ур чадварын сорилт
- Чулуун бүтээгдэхүүн, бэлэг дурсгалын зүйлийн үйлдвэрлэл

Геологийн төв лаборатори ТӨҮГ-ын удирдлага дараах хууль болон түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Ашигт малтмалын тухай хууль
- Цөмийн энергийн тухай хууль
- Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тухай хууль
- Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль
- Нийгмийн даатгалын тухай хууль
- Компанийн тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Геологийн төв лаборатори ТӨҮГ-ын Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг 2011 онд боловсруулсан боловч холбогдох стандарт, хууль тогтоомж, Сангийн яамнаас батлан гаргасан журам, нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлтэй нийцээгүй байна.

Геологийн төв лаборатори ТӨҮГ-ын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд “бага” буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Геологийн төв лаборатори ТӨҮГ нь санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Даймонд” програм хангамж ашигладаг байна.

Геологийн төв лаборатори ТӨҮГ-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт “Үр нөлөөтэй” гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Геологийн төв лаборатори ТӨҮГ-ын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 4 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 4 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлын үзүүлэлтийг сонгов.

Нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь уг байгууллага төрийн өмчит үйлдвэрийн газар, мөн олон тооны бага үнийн дүнтэй шинжилгээний борлуулалтууд хийгддэгтэй холбоотой.

Геологийн төв лаборатори ТӨҮГ-ын 2018 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн Нийт зардал 389.5 сая төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 3.9 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1 хувиар тооцсон нь тухайн байгууллага аудитын чиглэлүүдэд үзүүлж болзошгүй эрсдлийг харгалзан үзсэнтэй холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 4 чиглэлээр аудитын 4 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 3 алдаа зөрчил илэрсэн болно.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах асуудлыг залруулан санхүүгийн тайланд тусгаж, Геологийн төв лаборатори ТӨҮГ-ын удирдлагаар зөвшөөрүүлэн баталгаажуулав. Үүнд:

- Тайлант жилийн ашиг алдагдал буруу илэрхийлэгдсэн
- Өмнөх жилийн дуусаагүй үйлдвэрлэлийг хаалт хийгээгүйгээс стандарт загвар барааны өртөг буруу тооцоологдсон.
- Өртөг дутуу тооцоолсонтой холбоотой татварын зардал дутуу тооцоологдсон.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

2.8.2 . Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудал

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал /сая төгрөг/				
№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	2		
	Дүн	2		

2.8.2.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээс шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

1. Өртөг зардалтай холбоотой асуудал- 1

Дуусаагүй үйлдвэрлэл данс тайлант жилийн эцэст 272.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй байсан. Үүнтэй холбоотойгоор тайлант жилд борлуулсан барааны өртгийг 89.3 сая төгрөгөөр дутуу тооцоолсон.

Шийдвэрлэсэн нь: Алдааг залруулан өртгийг нь зөв тооцоолсон.

2. Бараа материалтай холбоотой асуудал- 2

Стандарт загвар барааны өртөг 182.9 сая төгрөгөөр дутуу тооцоологдсон.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх жилийн болон тайлант жилд дуусаагүй үйлдвэрлэл дансанд хуримтлагдсан 182.9 сая төгрөгийг стандарт загвар барааны үлдэгдэлд хувиарлан алдааг залруулан өртгийг зөв тооцоолсон.

3. Татварын өглөгтэй холбоотой асуудал

Өртөг дутуу тооцоолсон, хүүгийн орлогыг татвар ногдох орлогод тооцоогүй зэргээс 9.1 сая төгрөгний татварын зардал дутуу тооцоолсон.

Шийдвэрлэсэн нь: Алдааг залруулан татварын өглөгийг үүсгэсэн.

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар анхаарал татахуй чухал асуудал нь үйлдвэрлэсэн болон үзүүлсэн ажил үйлчилгээний өртгийн тайланг бэлтгэх.

2.10. Үйл ажиллагааны орлого, зардал, гүйцэтгэл, түүний талаарх тайлбар, тодруулга

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2017 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 600 дугаар тогтоолоор Геологийн төв лаборатори ТӨҮГ-ын 2018 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилт түвшинг баталсан байна.

Тайлант жилд зорилтот түвшингийн орлогын төлөвлөгөө 84.1 сая төгрөг буюу 2.4 хувиар давуулан биелүүлсэн байна. Зарлагын төлөвлөгөө 102.2 хувийн гүйцэтгэлтэй гарч 77.1 сая төгрөгөөр хэтэрсэн байгаа боловч орлогын төлөвлөгөө давж биелсний улмаас **85.9 сая төгрөгийн ашигтай** ажилласан байна.

Тус байгууллага нь тайлант онд борлуулалтын орлогоо 2.4 хувиар давуулан биелүүлсэн байгаа бөгөөд ажил үйлчилгээ ихэссэнтэй уялдаж бараа материалын, цахилгааны, түлш шатахууны зардлууд өсөж зардал төлөвлөсөн хэмжээнээс 2.2 хувиар хэтэрсэн үзүүлэлттэй гарсан байна.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Геологийн төв лаборатори ТӨҮГ-ын Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

Шилэн дансанд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгнөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийн нэгтгэсэн мэдээллийг, зорилтот түвшний гүйцэтгэлийг, хөрөнгө оруулалт, худалдан авалт, хагас жилийн санхүүгийн тайланг тус тус байршуулсан байна.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар 2 зөвлөмж, 1 албан шаардлага өгөгдсөн байна. Өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 100 хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Геологийн төв лаборатори ТӨҮГ-ын 2018 оны санхүүгийн тайланд аудит хийхдээ АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Геологийн төв лаборатори ТӨҮГ-ын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тусгасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, стандартад нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Геологийн төв лаборатори ТӨҮГ-ын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. НББ-ийн бодлогын бичиг баримттай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тус байгууллагын НБББББ-ийг 2011 онд боловсруулсан боловч байгууллагын үйл ажиллагааны онцлог, чиглэл, нягтлан бодох бүртгэлтэй нийцээгүй байна.

Эрсдэл:

НБББББ нь хангалтгүй байснаар СТОУС-ын дагуу нягтлан бодох бүртгэлийг хөтлөхөд хүндрэл гарах, буруу хэрэглэх, бүртгэлийн үйл ажиллагаа нь ажилтнуудын мэргэжлийн шийдлийн хүрээнд явагдахад сөрөг нөлөөлөл гарах.

Өгсөн зөвлөмж:

СТОУС болон холбогдох хууль журмын шаардлагад нийцсэн НБББББ-ийг боловсруулан, стандартын шинэчлэлт өөрчлөлтийг тухай бүр нэмэлт өөрчлөлт болгон тусгах нь зүйтэй.

Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

НБББББ-г шинэчлэн боловсруулж ажиллана.

2. Мөнгөн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Бэлэн мөнгөний нярав кассын бүртгэлийг гараар хөтөлдөггүй, өдөр бүр үлдэгдлээ бодитоор гаргахгүй байгаа нь Монгол Улсын Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар батлагдсан "Анхан шатны бүртгэлийн маягт зааврыг мөрдөж ажиллах" журамд нийцэхгүй байна.

Эрсдэл:

Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх болон хөрөнгө шамшигдуулах, мөнгөн хөрөнгийн хяналт сулрах

Өгсөн зөвлөмж:

Заавар журмыг мөрдөж ажиллах, өдөр бүр гараар бичиж кассын дэвтэр хөтлөх

Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Тус журмыг мөрдөж зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт байгууллагад 2019 оны 7 дугаар сарын 01-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан /төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2017 оны 12-р сарын 31	2018 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	60,335,251.76	561,376,931.37
1.1.2	Дансны авлага	1,360,365,976.64	1,306,439,851.24
1.1.6	Бараа материал	1,249,704,443.80	1,229,247,033.90
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/ тооцоо	22,962,600.35	17,762,800.00
	Эргэлтийн хөрөнгийн дүн	2,693,368,272.55	3,114,826,616.51
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	4,180,597,152.85	10,141,281,862.97
1.2.2	Биет бус хөрөнгө	8,986,527.68	133,992,641.68
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	4,189,583,680.53	10,275,274,504.65
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	6,882,951,953.08	13,390,101,121.16
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	217,485,878.27	201,824,756.66
2.1.1.3	Татварын өр	529,566,523.18	243,229,204.02
2.1.1.4	НДШ-ийн өр	1,094,172.20	1,228,141.07
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	481,684,863.47	508,458,390.43
	Богино хугацаат өр төлбөрийн дүн	1,229,831,437.12	954,740,492.18
2.1.2.1	Урт хугацаат өр төлбөр		
	Урт хугацаат өр төлбөрийн дүн	-	-
2.2	Өр төлбөрийн нийт дүн	1,229,831,437.12	954,740,492.18
2.3.	Эздийн өмч		
2.3.1	Төрийн	3,413,613,163.67	4,577,056,163.67
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	773,675,947.28	5,985,275,518.69
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	878,158,426.75	978,235,676.75
2.3.9	Хуримтлагдсан ашиг	587,672,978.28	894,793,269.88
2.3.11	Эздийн өмчийн дүн	5,653,120,515.98	12,435,360,628.99
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	6,882,951,953.10	13,390,101,121.17

4.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан /төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Борлуулалтын орлого(Цэвэр орлого)	3,410,260,574.74	4,240,179,071.28
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	2,754,696,568.83	3,483,489,953.18
3	Нийт ашиг (алдагдал)	655,564,005.91	756,689,118.10
4	Түрээсийн орлого	16,575,000.00	7,488,000.00
5	Хүүний орлого	95,616.78	2,449,898.51
8	Бусад орлого	-	21,677,200.00
9	Борлуулалт, маркетингийн зардал	-	41,732,620.64
10	Ерөнхий ба удирдлагын зардал	267,682,437.61	296,981,358.55
12	Бусад зардал	80,046,540.66	35,735,953.33
13	Гадаад валютын ханшийн зөрүүний бодит олз	1,836,892.57	2,039,349.40
	Гадаад валютын ханшийн зөрүүний бодит бус гарз	-5,644,578.47	-213,387.35
	Ханшийн тэгшитгэлийн бодит бус ашиг	128,079.39	4,844,496.45
	Ханшийн тэгшитгэлийн бодит бус алдагдал	-427,488.22	-2,132,654.14
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз	-1,314,544.60	-15,053,540.17
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	325,027,992.39	403,338,548.28
19	Орлогын татварын зардал	39,942,995.45	43,391,276.08
20	Татварын дараах ашиг (алдагдал)	279,141,009.64	359,947,272.20
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	279,141,009.64	359,947,272.20

4.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан /төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2017 оны 1 сарын 1-ний үлдэгдэл	3,413,613,163.67	-	773,675,947.28	878,158,426.75	308,531,968.64	5,373,979,506.34
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)					279,141,009.64	279,141,009.64
Өмчид гарсан өөрчлөлт						-
2017 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	3,413,613,163.67	-	773,675,947.28	878,158,426.75	587,672,978.28	5,653,120,515.98
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					-24,912,880.60	-24,912,880.60
Залруулсан үлдэгдэл	3,413,613,163.67		773,675,947.28	878,158,426.75	562,760,097.68	5,628,207,635.38
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)					359,947,272.20	359,947,272.20
Өмчид гарсан өөрчлөлт		1,163,443,000.00				1,163,443,000.00
Зарласан ногдол ашиг					-27,914,100.00	-27,914,100.00
Дахин үнэлгээний нэмэгдэл			5,211,599,571.41	100,077,250.00		5,311,676,821.41
2018 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	4,577,056,163.67	1,163,443,000.00	5,985,275,518.69	978,235,676.75	894,793,269.88	12,435,360,628.99

4.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан /төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	3,405,916,936.10	4,859,990,605.83
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	3,147,271,725.65	4,610,781,822.97
1.1.6	Бусад мөнгөн орлого	258,645,210.45	249,208,782.86
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	3,095,334,467.06	4,156,611,654.67
1.2.1	Ажилчдад төлсөн мөнгө	1,319,565,308.00	1,529,582,325.00
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	507,039,152.55	478,691,116.23
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	442,037,924.46	713,129,861.64
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	162,623,967.14	181,121,771.08
1.2.5	Түлш шатахуун, сэлбэг хэрэгсэлд төлсөн	52,419,619.24	147,864,348.24
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	25,765,576.74	-
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	477,833,114.20	912,395,789.68
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	1,005,120.00	8,278,702.72
1.2.9	Бусад мөнгөн зарлага	107,044,684.73	185,547,740.08
1.3	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний дүн	310,582,469.04	703,378,951.16
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	95,616.78	9,848,898.51
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	7,399,000.00
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	95,616.78	2,449,898.51
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	25,731,727.27	188,809,874.42
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	25,731,727.27	188,809,874.42
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны дүн	-25,636,110.49	-178,960,975.91
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	482,871,180.26	6,883,845.85
3.1.1	Зээл авсан өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	480,906,208.30	-
3.1.4	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	1,964,971.96	6,883,845.85
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	715,875,131.15	30,260,141.49
3.2.1	Зээл өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	709,803,064.46	-
3.2.4	Төлсөн ногдол ашиг	-	27,914,100.00
3.2.5	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	6,072,066.69	2,346,041.49
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний дүн	-233,003,950.89	-23,376,295.64
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	51,942,407.66	501,041,679.61
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	8,392,844.10	60,335,251.76
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	60,335,251.76	561,376,931.37

4.5 Аудит хийсэн зорилтот түвшин, гүйцэтгэл, түүний талаарх тайлбар, тодруулгын тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан /төгрөгөөр/

Д/Д	Эдийн засгийн үндсэн үзүүлэлт	2018		Зөрүү	
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Дүн (Илүү+, Дутуу-)
1	Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт:	3,476,010.7	3,546,706.2	102.0	70,695.5
	а) Гол нэр төрлөөр: -Шинжилгээний ажил	3,326,010.7	3,401,145.6	102.3	75,134.9
	-Чулуун бүтээгдэхүүн борлуулалт	85,000.0	85,750.0	100.9	750.0
	-Стандарт загварын борлуулалт	65,000.0	59,810.6	92.0	-5,189.4
	-Бусад орлого	40,683.0	54,043.8	132.8	13,360.8
	б) Үнийн дүнгээр	3,516,693.7	3,600,750.0	102.4	84,056.3
2	Нийт орлого	3,516,693.7	3,600,750.0	102.4	84,056.3
3	Нийт зардал	3,428,114.1	3,505,213.0	102.2	77,098.9
	Үүнээс: Удирдлагын захидал	289,963.6	295,377.0	101.9	5,413.4
4	Татварын өмнөх ашиг, алдагдал	88,579.6	95,537.0	107.9	6,957.4
5	Цэвэр ашиг (алдагдал)	76,921.6	85,940.0	111.7	9,018.4
6	Төрийн өмчийн ноогдол ашиг	15,384.3	16,406.8	106.6	1,022.5
7	Нийт ажиллагсдын тоо	158	158	100.0	-
8	Нийт цалингийн сан	1,750,919.2	1,851,826.0	105.8	100,906.8
9	Нэг ажилтны дундаж цалин	923.5	976.7	105.8	53.2
10	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	1.0	1.0	100.0	-
11	Нийт хөрөнгө оруулалт	1,789,900.0	1,535,100.0	85.8	-254,800.0
	Өөрийн хөрөнгөөр	432,992	178,200.0	41.2	-254,792.0
	Улсын төсвийн хөрөнгөөр	1,356,900.0	1,356,900.0	100.0	-
12	Нийт авлага	1,021,666.10	1,018,756.0	99.7	-2,910.1
	Үүнээс: Улсын төсвийн байгууллага	350,000.00	346,000.0	98.9	-4,000.0
	Оюутолгой ХХК-ын	290,000.00	225,000.0	77.6	-65,000.0
	Найдваргүй	30,000.00	30,000.0	100.0	-
13	Нийт өглөг	1,040,329.4	1,036,475.0	99.6	-3,854.4
	Богино хугацаат өр	1,040,329.4	1,036,475.0	99.6	-3,854.4
	Урт хугацаат өр төлбөр				-

5 Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	2019.03.05	Аудитын нэр:	Геологийн төв лаборатори ТӨҮГ-ын 2018 оны санхүүгийн тайлан, тодруулагад хийсэн аудитын тайлан	Аудитын код:
Шалгагдсан байгууллагын нэр:	ГЕОЛОГИЙН ТӨВ ЛАБОРАТОРИ ТӨҮГ			САГ-2019/68/СТА-ТӨҮГ
				Сая төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллага ас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
А	1	2	3	4	5
1	Тус байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг 2011 онд боловсруулсан боловч байгууллагын үйл ажиллагааны чиглэл нягтлан бодох бүртгэлтэй нийцээгүй байна.		Зөвлөмж	Нягтлан бодогч	Д.Мөнхтуяа
2	Бэлэн мөнгөний няравын кассын бүртгэл хөтлөлт сул, өдөр бүр кассын дэвтэр хөтөлж үлдэгдлээ бодитоор гаргахгүй байгаа нь Монгол Улсын Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар батлагдсан "Анхан шатны бүртгэлийн маягт зааврыг мөрдөж ажиллах" журамд нийцэхгүй байна.		Зөвлөмж	Нягтлан бодогч	Д.Мөнхтуяа
3	Тайлант жилийн ашиг алдагдал буруу илэрхийлэгдсэн.	89.2	Залруулга	Нягтлан бодогч	Д.Мөнхтуяа
4	Өмнөх жилийн дуусаагүй үйлдвэрлэлийг хаалт хийгээгүйгээс стандарт загвар барааны өртөг буруу тооцоологдсон	182.9	Залруулга	Нягтлан бодогч	Д.Мөнхтуяа
5	Өртөг дутуу тооцоолсонтой холбоотой татварын зардал дутуу тооцоологдсон	9.1	Залруулга	Нягтлан бодогч	Д.Мөнхтуяа
	Дүн	281.3			

